# УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ТОГТООЛ

2020 оны 3 сарын 10 өдөр Дугаар 5 Улаанбаатар хот

Зорчигч тээврийн хөдөлгөөнийг
түр зогсоох тухай

Улсын онцгой комиссын 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн X хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсад коронавируст халдвар (COVID-19)-ын анхны батлагдсан тохиолдол Франц Улсаас зөөвөрлөгдөн орж ирсэн тул халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэл, аймаг, сумаас гарах хот хоорондын зорчигч тээвэр болон хувийн тээврийн хэрэгсэл, орон нутгийн хуваарьт нислэг, суудлын галт тэрэгний хөдөлгөөнийг 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 07:00 цагаас 3 дугаар сарын 16-ны өдрийн 07:00 цаг хүртэл түр зогсоож холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Цагдаагийн ерөнхий газрын дарга, бригадын генерал С.Баатаржав, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү, аймаг, нийслэлийн Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА Ө.ЭНХТҮВШИН

УХА0168